



МОНГОЛ УЛС
АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

65139 Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 2 дугаар баг,

Утас/Факс: (976) 7033 3208,

И-мэйл: arkhangai.gov@gmail.com,

Вэбсайт: www.arkhangai.gov.mn

2023 04.14 № 02/619

танай _____-ны № _____-т

МОНГОЛЫН ОЛБОРЛОХ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН
САНААЧЛАГЫН АЖЛЫН АЛБАНД

Тус аймгийн дэд зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт болон 2023 оны ажлын төлөвлөгөөг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт: ...хуудастай.

ОРЛОГЧ



Б.САНЖМЯТАВ

6513940301

АРХАНГАЙ АЙМГИЙН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫН
2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
/Жилийн эцсийн байдлаар/

2023.04.03

№	ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ	БИЕЛЭЛТ
1	Орон нутгийн төсөвт хүлээн авсан татвар, төлбөр, хандив дэмжлэгийн мэдээг гарган программд шивж оруулан нэгдсэн дүнг ОУИТБС-ын ажлын албанд хүргүүлэх	Санхүү, татварын мэдээлэлтэй тулган баталгаажуулсны үндсэн дээр программд шивж оруулан нэгдсэн дүнг ОУИТБС-ын ажлын албанд хүргүүлсэн.
2	Ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжүүдийн орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд төвлөрүүлж байгаа орлого тухайн сум орон нутгийн хөгжилд хэрхэн нөлөөллөө үзүүлж, үр ашгаа үзүүлж байгаа талаар болон хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж байгаа аж ахуй нэгжүүдийг олон нийтэд мэдээллэх	Архангай аймагт Ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулж буй "БМНС" ХХК 2022 онд усны нөөц ашигласны төлбөрт 84 сая төгрөг, "Ашид бэхи" ХХК нь Эрдэнэбулган суманд авто тээвэр, ашигт малтмал ашиглалтын төлбөр, хог хаягдал, ус ашигласны төлбөр нийт 13,120,000 төгрөгийн татварыг төлсөн байна.
3	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон нутгийн захиргааны байгууллагын хооронд байгуулсан гэрээ бүрийг www.iltodgeree.mn эрдэс баялгийн гэрээний мэдээллийн санд байршуулах	Аймгийн хэмжээнд хамтран ажиллах гэрээ байгуулсан 1 аж ахуй нэгж (БМНС ХХК) Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээх үйл ажиллагааны гэрээг 1 аж ахуй нэгжтэй байгуулан (Батделгөөн мөрөн ХХК-) нийт 2 гэрээг www.iltodgeree.mn байршуулсан.
4	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутгийн дэд зөвлөлийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор түүний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, холбогдох зардлыг жил бүрийн орон нутгийн төсөвт тусгаж ажиллах	Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачилгын дэмжих ажлын хүрээнд аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг нь аймгийн Засаг даргын нөөц сангийн болон Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачилгын ажлын албаны санхүүжилтээр уул уурхайн олборлолтын нөлөөллийн бүсийн иргэд болон, сумдад сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж, тус ажилд 4500 орчим иргэн хамрагдаж, 2000 орчим сурталчилгааны материал тараалаа. Дэд зөвлөл олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачилгын ажлын албанаас болон Ашигт малтмал, газрын тосны газраас зохион байгуулсан 4 удаагийн сургалтуудад бүрэн хамрагдлаа.
5	Орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын ашигт малтмалын хайгуул, олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй компаниудаас нийгмийн хариуцлагын хүрээнд хүлээн авсан мөнгөн болон мөнгөн бус хандивыг нийтэд мэдээллэх ажлыг холбогдох хуулийн дагуу зохион байгуулах	"Ашид Бэхи" ХХК нь 2022 онд нийгмийн хариуцлагын хүрээнд үйлдвэрийн хашаанд 250 мод тарьж, Эрдэнэбулган сумын 5-р цэцэрлэгийн 80 жилийн ойд зориулан 250 хүүхдэд гарын бэлэг, 4 сая төгрөгний дэмжлэг үзүүлсэн. Турк улсад зохион байгуулагдсан 100 буудалт даамны тэмцээнд оролцсон хүүхдэд 4 сая төгрөг, Архангай аймгийн бурханы шашинтны төв төгс баясгалант буян дэлгэрүүлэх хийдийн шинэ цогчин дуганы барилгын сууринд хэрэглэгдэх 11,3 сая бүхий хайрга, цагдаагийн шинэ барилгад 1,2 сая төг бүхий хайрга нийлүүлээд байна.

ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫГ ДЭМЖИХ АЖЛЫН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2022 он

Архангай аймгийн Цэнхэр сумын Орхон багт 1999 оноос хойш алт олборлох үйл ажиллагаа явуулж байсан ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч 11 аж ахуй нэгжийн ашиглалтын 12, хайгуулын 1 тусгай зөвшөөрлийг 2019 оны 8-р сарын 21-ны өдөр "Ашигт малтмалын тухай" хуулийн 56-р зүйлийн 56.1.5 дах хэсэгт заасны дагуу Архангай аймгийн Засаг даргын санал, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын шийдвэрээр цуцалж алт олборлох үйл ажиллагааг зогсоон эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх ажлыг эхлүүлсэн.



Ашигт малтмалын тусгай зөвшөөрлөө цуцлуулсан 11 аж ахуй нэгж дээрх шийдвэрийг эсэргүүцэн шүүхийн байгууллагад гомдол гаргаж 2022 оны байдлаар Цэнхэр сумын Орхон багийн I үүтийн ам гэх газарт "Сэншивэе Монгол" ХХК-ийн MV-017316 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл, Шийрт, Харгуйтын ам гэх газарт "Батдөлгөөн мөрөн" ХХК-ийн MV-005529 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл, Өлийн голын адаг гэх газарт "Гурван хайрханы асар" ХХК-ийн MV-004174 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл, Өлзийт тээл гэх газарт "БМНС" ХХК-ийн MV-001410 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл, Бодонт гэх газарт "Голден хаммер" ХХК-ийн MV-004780 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл, Өлийн гол гэх газарт "Улз групп" ХХК-ийн MV-020442 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл, Ар чулуутын ам гэх газарт "Алтай голд" ХХК-ийн MV-012470 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл, Өлзийт тээл гэх газарт "Эрдэнэсийн хотхон" ХХК-ийн XV-006219 дугаартай хайгуулын тусгай зөвшөөрлүүдийг гурван шатны шүүхийн шийдвэрийг үндэслэн Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын шийдвэрээр сэргээсэн.

2022 онд аймгийн Засаг даргын 07 дугаар сарын 08-ны өдрийн А/536 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулан Цэнхэр сумын Орхон багт хууль бусаар ашигт малтмал олборлох эрсдэлээс урьдчилан сэргийлэх хяналтын постыг аймгийн Цагдаагийн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Орхон-Чулуут голын сав газрын захиргаа, Цэнхэр сумын Засаг даргын тамгын газартай хамтран 7 дугаар сарын 25-ны өдрөөс 11 дүгээр сарын 13-ны өдрийг хүртэлх хугацаанд тогтмол хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн байна.

2021 онд ашигт малтмал ашиглалтын MV-001410 дугаартай тусгай зөвшөөрлийг эзэмшигч "БМНС" ХХК нь Өлзийт тээл гэх газарт Ашигт малтмалын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид шаардагдах уурхайд байх баримт бичгийг батлуулан 2 га талбайд хөрс хуулалт, олборлолтын ажил, 15 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 25 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хууль журмын хүрээнд хийж гүйцэтгэсэн. Бусад аж ахуй нэгжийн уул уурхайн олборлолтын ажлыг эхлүүлээгүй болно.

2022 онд ашигт малтмал ашиглалтын MV-001410 дугаартай тусгай зөвшөөрлийг эзэмшигч "БМНС" ХХК, MV-004780 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Голден хаммер" ХХК, MV-004780 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Улз групп" ХХК-ууд Ашигт малтмалын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид шаардагдах уурхайд байх баримт бичгийг батлуулсан боловч "Голден хаммер" ХХК, "Улз групп" ХХК-ийн бичиг баримт олборлолт хийх боломжит хугацаа буюу 4 дүгээр сараас 10 дугаар сарын хугацаанд багтаж батлагдаагүй тул үйл ажиллагаа явуулаагүй.

Тус онд БМНС ХХК 4.7 га талбайд хөрс хуулалт, олборлолтын ажил, 10 га талбайд техникийн 8 га талбайд биологийн нөхөн сэргээлт (3101.2 сая), Гурван хайрханы асар ХХК 6 га талбайд техникийн нөхөн сэргээлт (240 сая), Батдөлгөөн мөрөн ХХК 8 га талбайд техникийн нөхөн (135 сая) сэргээлтийг тус, тус хийж гүйцэтгэсэн.

Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачилгын дэмжих ажлын хүрээнд аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг нь аймгийн Засаг даргын нөөц сангийн хөрөнгө болон Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачилгын ажлын албаны санхүүжилтээр уул уурхайн олборлолтын нөлөөллийн бүсийн иргэд болон, сумдад сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж, тус ажилд 4500 орчим иргэн хамрагдаж, 2000 орчим сурталчилгааны материал тараалаа.

Дэд зөвлөл олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачилгын ажлын албанаас болон Ашигт малтмал, газрын тосны газраас зохион байгуулсан 4 удаагийн сургалтуудад бүрэн хамрагдлаа.



---ooOoo---